



**ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 5/23

Чингис хот

**Б.Цэцэгмаагийн албан тушаалын  
зэрэглэлийг ахиулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь заалт, Засгийн газрын 2007 оны "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 354 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, 2019 оны 24 дүгээр тогтоол "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай"-ын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж тус газрын 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 05/3108 тоот албан бичгээр ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй, 2016 онд мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авч, Сангийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/59, 2019 оны А/47 дугаар тушаалаар нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчаар томилогдсон Болдонгомбын Цэцэгмаагийн албан тушаалын зэрэглэлийг ахиулан 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгосугай.

2. Б.Цэцэгмаагийн цалинг ТЗ-6-4 шатлалаар тогтоон үндсэн цалин 752976 /долоон зуун тавин хоёр мянга есөн зуун далан зургаан/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

3. Б.Цэцэгмаад томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, эрх бүхий албан тушаалтан /Ж.Гантулга/-д гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР